



Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төсөл ТББ-ийн өгөгдлийн хүснэгтэд дараах зөрчлөлийг оруулав

2024.12.03

ТШЗ-ны холбогдох заалт	ТББ-т туссан	Өөрчлөх
	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт :"Шаардана" Орчуулагч гэрээт ажилтан байна болно</p> <p>Дээрх бичиг баримтыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй бөгөөд үнэн зөвийг тендерт оролцогч бүрэн хариуцна.</p>	Хасах
ТШЗ 18.1	<p>Дээрх ажилтнууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 1 жил тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг нотлох. НД7, НД8</p> <p>1 жилийн туршид нийлүүлэгч компанид тогтвор суурьшилтай тасралтгүй ажилласан эсэхийг нотлох баримтаар ирүүлэх, Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл "Шаардана"</p> <p>Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэрээр батлагдсан төсөвт өртгийн 80%-иас багагүй дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, бараа хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн, протоколын хуулбарыг нотариат (тендер зарласан өдрөөс хойш хугацаатай байх)-аар гэрчлүүлж ирүүлнэ. Мөн гэрээт бараагаа хугацаанд нь чанартай нийлүүлсэн эсэх тухай захиалагчийн тодорхойлолт (тендер зарласан өдрөөс хойш хугацаатай байх)-ыг ирүүлэх ба бараа нийлүүлснийг төлбөрийн баримт, и-баримтаар нотолж ирүүлнэ.</p>	<p>Орчуулагчаас бусад ажилтнууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх ба сүүлийн 6 сард нийгмийн даатгал төлсөн НД7, НД8 тайлан ирүүлэх.</p> <p>Хасах</p> <p>Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 оны аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 50%-иас багагүй дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, бараа хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн протоколыг ирүүлнэ. Гэрээт бараагаа хугацаанд нь чанартай нийлүүлсэн эсэх тухай захиалагчийн тодорхойлолт (тендер зарласан өдрөөс хойш хугацаатай байх)-ыг ирүүлэх ба бараа нийлүүлснийг төлбөрийн баримт, и-баримтаар нотолж ирүүлнэ.</p> <p>Жич: Дээрх баримт бичгийг ирүүлээгүй, дутуу ирүүлсэн, гэрээний үүргээ зөрчиж байсан нь нотлогдсон тохиолдолд уг тендерээс таггалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 19.1	<p>2021, 2022, 2023 оны санхүүгийн аудитлагдсан дүгнэлттэй тайланг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ</p> <p>4. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн 80%-иас багагүй байна.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:</p> <p>4.1 Байгууллагын харилцагч банкна дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа</p> <p>4.2 Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт</p> <p>4.3 Үнэт цаас, Засгийн газрын бонд боон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд</p> <p>4.4 Төлөөлөх эрх бүхий гишүүн түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнгийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.(Тус заалтыг тодруулгаар нэмж оруулсан)</p>	<p>2021, 2022, 2023 оны санхүүгийн аудитлагдсан дүгнэлттэй тайланг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ. (Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэггүй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт ирүүлэхгүй байж болно.)</p> <p>4. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн 80%-иас багагүй байна.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:</p> <p>4.1 Харилцагч банкны мэдэгдэл;</p> <p>4.2. Төлөөлөх эрх бүхий гишүүн түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн нийт дүнгийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. (Тус заалтыг тодруулгаар нэмж оруулсан)</p>
	<p>14.2 Оролцогч нь үйлдвэрлэгчийн дистрибьютерийн эрхтэй бол үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. Үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрөл гэдэгт дараах баримтуудын аль нэг нь байж болно. Үүнд: дистрибьютерийн гэрчилгээ, дистрибьютерийн хамтын ажиллагааны гэрээ, бусад нотлох баримт.</p>	<p>14.2 Оролцогч нь үйлдвэрлэгчийн дистрибьютерийн эрхтэй бол үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрлийг ирүүлнэ. Үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрөл гэдэгт дараах баримтуудын аль нэг нь байж болно. Үүнд: дистрибьютерийн гэрчилгээ, дистрибьютерийн хамтын ажиллагааны гэрээ, бусад нотлох баримт,</p>